

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

Хүчний трансформаторын чадал
тодорхойлох багаж, кабелийн трасс
тодорхойлох багаж,
трансформаторын ороомгийн
эсэргүүцэл хэмжих багаж,
газардуулгын эсэргүүцэл хэмжих
багаж, тестер нийлүүлэх
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
тендерийн баримт бичиг

Тендер шалгаруулалтын дугаар:

ХАН№19/07

Хаяг:

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”
ТӨХК-ний конторын байр

Утас:

99020551

Факс:

70210167

ХАН№19/07 тоот тендерийн урилга

Хүчний трансформаторын чадал тодорхойлох багаж, кабелийн трасс тодорхойлох багаж, трансформаторын ороомгийн эсэргүүцэл хэмжих багаж, газардуулгын эсэргүүцэл хэмжих багаж, тестер нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр илгээж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn сайтаас /Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/ татаж үзнэ үү.

Хаяг :

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ний
конторын байр 202 тоот өрөө

Утас: 99020551

Факс: 70210167

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг цахимаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Санал болгож буй материалыг үнийн саналын маягтын дагуу ирүүлэх;
 - (б) Нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) ТООЗ 1.1 дэх заалтын дагуу бусад материалыг бэлтгэж ирүүлэх.
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар 2. Үнийн санал /маягтын дагуу/ 3. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар, НӨАТ биш бол энэ тухай албан бичиг ирүүлэх 4. Сүүлийн нэг /2018 он/ жилийн борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дахь заалтын дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/ 5. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхийн ямар нэгэн зарга маргааны талаарх тодорхойлолт. /Шүүхийн төрөлжсөн архив, Шийвдэр гүйцэтгэх албанаас тус тус ирүүлэх/ 6. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх /Татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын тендерийн лавлагааг үндэслэнэ/ 7. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолтыг ирүүлэх /Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх/ 8. Тендерт оролцогч нь ГТН 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 9. Нийлүүлэх хугацаа нь гэрээ байгуулсанаас хойш 21 хоногоос ихгүй, хүргэх газар Багануур дүүргийн үйлдвэрийн хэсгийн “БЗӨБЦТС” ТӨХК-ийн агуулахад 10. Одоо хэрэгжүүлж буй бараа материал нийлүүлж байгаа гэрээний жагсаалтыг маягтын дагуу ирүүлэх. 11. Ижил төстэй ажлын жагсаалт гэрээ, гэрээ дүгнэсэн акт тэдгээрийн ажлын өртөг, хугацаа байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлэх./2016-2018 онуудын аль нэгэнд/ 12. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан нь тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн 13 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх.</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Нээлтийг 2019 оны 04 дугаар сарын 01-ны өдрийн 13 цаг 30 минутаас цахим системээр нээнэ.</p> <p>УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн өөрийн байр, 2-р давхар 202 тоот өрөө 99020551</p>
ТӨӨЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий байна:</p> <p>ХАН №19/07 “Хүчний трансформаторын чадал тодорхойлох багаж, кабелийн трасс тодорхойлох багаж, трансформаторын ороомгийн эсэргүүцэл хэмжих багаж, газардуулгын эсэргүүцэл хэмжих багаж, тестер нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг”</p> <p>Багцтай эсэх: Үгүй</p>

Гурав. БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тодорхойлолт
1	Кабелийн трасс тодорхойлогч багаж	ш	1	Батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу
2	Хүчний трансформаторын чадал тодорхойлогч багаж	ш	1	
3	Трансформаторын ороомгийн эсэргүүцэл хэмжих багаж	ш	1	
4	Газардуулгын эсэргүүцэл хэмжигч багаж (KYORITSU Earth tester 4105 DL загварын тестертэй дүйцэхүйц)	ш	1	
5	Тестер (Fluke загвартай дүйцэхүйц)	ш	5	

БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

КАБЕЛИЙН ТРАСС ТОДОРХОЙЛОГЧ БАГАЖ

Кабелийн трасс тодорхойлогч нь дараах техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, Олон улсын IEC стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн, загварын хувьд ашиглагдан туршигдсан, шинэ кабелийн трасс хайгч байх ёстой. Ашиглалтын заавар Монгол, Англи хэлээр байх.

д/д	Үзүүлэлт	Функцин төрөл	
1	Үйл ажиллагааны зориулалт	<ul style="list-style-type: none"> - Газар доорх сүлжээний хайлт хийнэ - Кабель болон бусад газар доорх кабелийн /хүчдэлтэй хүчдэлгүй/ гүнийг тодорхойлно - Кабелийн гэмтэлтэй цэгийг тодорхойлно 	
2	Иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> - Генератор /Хүлээн авагч болон бусад төхөөрөмжтэй зайнаас холбогддог байх/ - хүлээн авагч 	
3	Техникийн үзүүлэлт	Мэдрэх чадвар	6E-15 Тесла , 5мкА, 1 метр зайнд /33Гц/
4		Динамик диапазон	140дБ-120дБ/Гц
5		Гүний хэмжилтийн нарийвчлал	<ul style="list-style-type: none"> - Шугам: 0,1-3 метрт 2,5% - Зонд: 0,1-7 метрт 2,5%
6		Хамгийн их гүн	- Шугам: 6м, зонд: 18м
7		Хайлтын нарийвчлал	- 2,5%
8		CD Fault-Finding ээр гэмтэл илрүүлэх	- Гэмтэл илрүүлэх–220Гц-ээс 4кГц
9		Fault-Finding ээр гэмтэл илрүүлэх	- Богино залгаанаас үүссэн гэмтлийг “А” рамын тусламжтай илрүүлэхэд 2МОм
10		Тэжээлийн зай хураагуур	<ul style="list-style-type: none"> - Хүлээн авагч- 2x D-cells /LR20/ - Генераторт – 8x D- cells /LR20/
11		Зай хураагуураас ажиллах хугацаа	Хүлээн авагч 30 цаг, генератор 15 цаг
12		Баталгаат хугацаа	Бүртгэснээс хойш 36 сар
13		Хэт ачааллын хамгаалалт	30дБ

14	Хангасан шаардлага	ФКС, RSS310RoHS, Weee
----	--------------------	-----------------------

ТРАНСФОРМАТОРЫН ОРООМГИЙН ЭСЭРГҮҮЦЭЛ ХЭМЖИГЧ БАГАЖНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Трансформаторын ороомгийн эсэргүүцэл хэмжигч багаж нь доор дурьдсан техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, олон улсын IEC стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн, загварын хувьд ашиглагдан туршигдсан, шинэ багаж байна.

Ерөнхий үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Тавигдах шаардлага
1	Гаралтын гүйдэл	10A, 5A, 1A, 100mA, 5mA
2	Хэмжих хязгаар	0~0.6Ω (10A) 2mΩ~3Ω (5A) 10mΩ~20Ω (1A) 100mΩ~200Ω (100mA) 200Ω~20kΩ (<4mA)
3	Нарийвчлал	0.1 μΩ
4	Хамгийн бага алдаа	0.2%±4μΩ
5	Ажиллах температур	- 20 хэмээс + 40 хэм
6	Орчны чийгшил	≤90%
7	Ажиллах хүчдэл, давтамж, тэжээл	AC220V±10%, 50 Hz ±1Hz , ажлын горимын үед 12 цагаас дээш хугацаанд цэнэгээ барих 15 Ah багагүй баттарейтай байх
8	Дагалдах зүйл	Төхөөрөмж нь 2м урттай уян хатан халуун хүйтэнд тэсвэртэй, холбох хавчааран үзүүртэй байх ба эвхэж авч явахад хялбар дамартай 5м урттай, халуун хүйтэнд тэсвэртэй нөөц үзүүртэй байна. Үзүүрүүд хоорондоо орооцолдохооргүй тус тусад нь хийх боломжтой хатуу хайрцагтай байна. Доргилт, ус чийгнээс хамгаалагдсан IP55 стандарт хангасан зөөврийн зориулалтын хайрцаг, кейстэй байх

ГАЗАРДУУЛГЫН ЭСЭРГҮҮЦЭЛ ХЭМЖИГЧ БАГАЖНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Газардуулгын эсэргүүцэл хэмжигч багаж нь доор дурьдсан техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, олон улсын IEC стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн, загварын хувьд ашиглагдан туршигдсан шинэ багаж байна.

№	Техникийн үзүүлэлт	Тавигдах шаардлага
1	Хэмжих утга	0,01 Ом – 2000 Ом
2	Гаралтын хүчдэл	25В, 50В
3	Гүйдэл	450 мкА -4.5 мА
4	Дэлгэц	LCD
5	Орчны температур	-25 хэмээс +40 хэм
6	Тэжээлийн хүчдэл	DC 12В, LR6 AA 1.5В
7	Хэмжилтийн алдаа	0.5%

8	Хэмжих гаргалгаа	4 шонтой
9	Тэжээл	1,5В*6ш АА батерейтэй байх
10	Дагалдах зүйл	Хүчдэл шалгах нэмэлт үзүүртэй байх
		Газардуулга болон хөрсний хувийн эсэргүүцэл хэмждэг байх, зөөврийн зориулалттай, Багаж өөрийгөө шалгах эталон эсэргүүцэлтэй байх шаардлагатай.
		Төхөөрөмжийн хэмжилт хийх үзүүр нь уян хатан халуун хүйтэнд тэсвэртэй эвхэж авч явхад хялбар дамартай хоорондоо орооцолдхооргүй тус тусад нь хийх боломжтой хатуу хайрцагтай байна.
		Үндсэн 2 гадаснаас гадан нөөц 2 гадастай байна.

ХҮЧНИЙ ТРАНСФОРМАТОРЫН ЧАДАЛ ТОДОРХОЙЛОГЧ БАГАЖНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хүчний трансформаторын чадал тодорхойлогч багаж нь доор дурдагдах техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, Олон улсын ИЕС стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн, загварын туршилтаар туршигдсан, шинэ багаж байна.

Техник үзүүлэлтүүд:

1. Батгарейны гаралтын хүрээ

- Хүчдэл: 0 - 10V
- Гүйдэл: 0 - 10A

2. Хэмжих хүрээ

- Хүчдэл: 0 - 750V
- Гүйдэл: 0 - 100A

3. Нарийвчлалын зэрэглэл

- Хүчдэл, гүйдэл: 0.2% унших утга
- Хүчин чадал: - $\text{Cos}\Phi \geq 0.3$ үед 0.2%
- $0.3 > \text{Cos}\Phi > 0.1$ үед 0.5%
- $0.1 \geq \text{Cos}\Phi \geq 0.02$ үед 1.0%

4. Ажиллах температур: -20°C –аас +60°C хүртэл

5. Цэнэглэх хүчин чадал: AC 100V - 265V, 50Hz/60Hz

6. Тусгаарлагч:

- Оролтын терминал болон корпусын (хайрцаг, контейнер) хоорондын тусгаарлах эсэргүүцэл $\geq 100\text{M}\Omega$
- 50Hz–ийн үед хүчдэл тэсвэрлэх чадвар (оролтын хүч–корпус), 1 минутанд 2kV(үр дүнтэй утга)

7. Багажны хэмжээ: 32см×25см×12см

ТЕСТЕРИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Тестер нь доор дурдагдах техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, Олон улсын ИЕС стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн, загварын туршилтаар туршигдсан, шинэ багаж байна.

д/д	Функц	Хэмжих хязгаар	Resolution	Нарийвчлал
1	AC /V/ (40 Hz - 500Hz)	4.000 V 40.00 V 400.0 V 1000 V	0.001 V 0.01 V 0.1 V 1 V	1.0 % + 3
2	DC /V/	4.000 V 40.00 V 400.0 V 1000 V	0.001 V 0.01 V 0.1 V 1 V	0.5 % + 3
3	AC /mV/	400.0 mV	0.1 mV	3.0 % + 3
4	DC /mV/	400.0 mV	0.1 mV	1.0 % + 10
5	Сигнал	2.000 V	0.001 V	10%
6	Эсэргүүцэл /Ohms/	400.0 Ω 4.000 kΩ 40.00 kΩ 400.0 kΩ 4.000 MΩ 40.00 MΩ	0.1 Ω 0.001 kΩ 0.01 kΩ 0.1 kΩ 0.001 MΩ 0.01 MΩ	0.5 % + 3 0.5 % + 2 0.5 % + 2 0.5 % + 2 0.5 % + 2 1.5% + 3
7	Багтаамж	40.00 nF 400.0 nF 4.000 μF 40.00 μF 400.0 μF 1000 μF	0.01 nF 0.1 nF 0.001 μF 0.01 μF 0.1 μF 1 μF	2 % + 5 2 % + 5 5 % + 5 5 % + 5 5 % + 5 5 % + 5
8	Давтамж Hz (10 Hz – 100 kHz)	50.00 Hz 500.0 Hz 5.000 kHz 50.00 kHz 100.0 kHz	0.01 Hz 0.1 Hz 0.001 kHz 0.01 kHz 0.1 kHz	0.1 % + 3
9	AC гүйдэл /μA/ (40 Hz - 400 Hz)	400.0 μA 4000 μA	0.1 μA 1 μA	1.5 % + 3
10	AC гүйдэл /mA/ (40 Hz to 400 Hz)	40.00 mA 400.0 mA	0.01 mA 0.1 mA	1.5 % + 3
11	AC гүйдэл /A/ (40 Hz - 400 Hz)	4.000 A 10.00 A	0.001 A 0.01 A	1.5 % + 3
12	DC гүйдэл /μA/	400.0 μA 4000 μA	0.1 μA 1 μA	1.5 % + 3
13	DC гүйдэл /mA/	40.00 mA 400.0 mA	0.01 mA 0.1 mA	1.5 % + 3
14	DC гүйдэл /A/	4.000 A 10.00 A	0.001 A 0.01 A	1.5 % + 3
15	Температур	50 °C- 400 °C 0 °C- 50 °C -55 °C- 0 °C	0.1C	2 % ± 1 °C ± 2 °C 9 % ± 2 °C
16	Дэлгэцний гэрэл	-	-	Тийм

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны сарынөдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ажлын [санал болгож буй нийлүүлэх хугацааг бичнэ] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Техникийн тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Нийлүүлэхээр санал болгож буй бараа материалыг захиалагчийн томилсон ажлын хэсэг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо үйлдвэрийн хэсэг БЗӨБЦТС ТӨХК-ийн агуулахад |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 (нэг) жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор барагдуулна. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1 Нийлүүлэхээр санал болгож буй материалыг захиалагчийн томилсон ажлын хэсэг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан тохирлын гэрчилгээ, ашиглалтын заавар Монгол хэл дээр байна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний төлбөрийг гэрээ дүгнэсэн акт болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 60 хоногийн дотор төлбөрийг барагдуулна.
. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: Нэг хоногийн 0,5%

Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 10% |